



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 10 сарын 01 өдөр

Дугаар A/78

Улаанбаатар хот

Зочид буудал, дэн буудал,
амралтын газрын үйл ажиллагаа
эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй
болгох тухай

Монгол Улсын Аялал жуулчлалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын 5.1, Газрын дүрмийн 2.5.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008” стандартын шаардлагыг хангасан, тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид Зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007” стандартын шаардлагыг хангасан, тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан иргэн, аж ахуйн нэгжид Дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

3. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Амралтын газарт тавигдах ерөнхий шаардлага MNS6043:2009” стандартын шаардлагыг хангасан, тушаалын гуравдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид жуулчны баазын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Молор трейд ХХК-ийн “Олимп” зочид буудлын 17/244, Амури оргил ХХК-ийн “Гранд хилл” зочид буудлын 17/218, Ган оюу

1150500259

шонхор ХХК-ийн “Шонхор” дэн буудлын 17/089, Молор трейд ХХК-ийн “Их тамир” амралтын газрын 17/245 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

5. Зөвшөөрөл авсан байгууллага болон иргэдтэй гэрээ байгуулж үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Д.Ганболд/-т үүрэг болгосугай.

6. Энэхүү тушаалыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг Үйлчилгээний байгууллага, стандарт хариуцсан мэргэжилтэн /Б.Амар/-д үүрэг болгосугай.


7. Гэрчилгээний үнэ болох 5000 /таван мянга/ төгрөгийг байгууллага болон иргэн тус бүрээс хураан, Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн, зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Б.Батцож/-д даалгасугай.

ДАРГА



Д.БАТСҮХ

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2018 оны 10
сарын 01 өдрийн А/78 дугаар
тушаалын нэгдүгээр хэвсрэлт




ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2018.10.01

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Молор трейд ХХК	2571869	Олимп	СБД-ийн 19-р хороо хандгайт
2	Амури оргил ХХК	5378125	Гранд хилл	БГД-ийн 18-р хороо Жалханц хутагт Дамдинбазарын гудамж 52

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2018 оны 10
сарын 01 өдрийн А/78 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт



ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2018.10.01

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Ган оюу шонхор ХХК	5274281	Шонхор	СХД-ийн 4-р хороо Их нарангийн 1-1а
2	Баттэгш зам ХХК	2741555	Оюут	БГД-ийн 4-р хороо 2-р хороолол 7-р байр өргөтгөл

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2018 оны 10
сарын 01 өдрийн А/78 дугаар
тушаалын гуравдугаар хавсралт

5284325 СБТ 8936 1118263502

АМРАЛТЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2018.10.01

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Молор трейд ХХК	2571889	Их тамир	СБД-ийн 19-р хороо Хандгайт